

ЗАГВАР 10: АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ЗАГВАР

(Төрийн өмчит үйлдвэрийн газар)

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дарханы дулааны сүлжээ ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2026/2/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn
Дархан-Уул аймаг
2026 он

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр
Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn
Аудитын менежер: У.Батсүрэн
Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn
Аудитор: Б.Алтанзул, Н.Хулансүрэн
Утас: 70373089 Цахим хаяг: altanzulby@audit.gov.mn,
khulansurenn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45008
Утас: 7037-3089, Факс: (976) 7037 3089
Цахим шуудан: darhanuu@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.11 № 171
төний _____ -ны № _____ -т

"ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ"
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.БАТЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дарханы дулааны сүлжээ" ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд үйл ажиллагааны бус орлогыг 170.7 хувиар биелүүлснээр төлөвлөсөн алдагдал 1,445,803.3 мянган төгрөгөөр буурч 270,736.7 мянган төгрөгийн алдагдлыг санхүүгийн тайланд тодруулж толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 56 дугаар тогтоолоор тус байгууллагад худалдах дулааны эрчим хүчний үнийг 7,100.00 төгрөгөөс 2,290.00 төгрөг болгон бууруулж, 2025 оны 03 дугаар сарын 01-

4529050301

ний өдрөөс мөрдөж эхэлснээр худалдан авсан дулааны эрчим хүчний өртөг өнгөрсөн оноос 2,097,205.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 25 зорилтын хүрээнд 91 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 3 ажил үргэлжлэн хэрэгжих шатандаа, бусад 88 ажил бүрэн хэрэгжиж, гүйцэтгэлийг 96.7 хувиар тайлагнасан байна. Мөн тайлант онд 2025 оноос 2026 оны өвөлжилтийн бэлтгэл хангах их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтаар нийт 41 ажил төлөвлөснөөс 38 ажил бүрэн хэрэгжиж, гүйцэтгэлийг 92.7 хувиар тайлагнажээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	325,523,315.24	483,232,989.60
1.1.2	Дансны авлага	615,813,321.60	533,127,518.60
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	58,015,674.11	87,728,712.39
1.1.4	Бусад авлага	316,130,255.15	309,420,949.49
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	614,467,772.76	622,036,649.74
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6,794,487.20	10,187,109.29
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,936,744,826.06	2,045,733,929.11
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	23,326,906,411.19	25,373,065,304.34
1.2.2	Биет бус хөрөнгө	1,026,453,702.32	1,269,367,234.84
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	24,353,360,113.51	26,642,432,539.18
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	26,290,104,939.57	28,688,166,468.29
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	67,035,392.71	87,849,435.71
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	526,880.28	-
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	470,000,000.00	400,000,000.00
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	110,166,603.96	117,118,724.06
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	647,728,876.95	604,968,159.77
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	647,728,876.95	604,968,159.77
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	17,920,722,852.44	17,920,722,852.44
2.3.2	Өмч: - хувийн	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,915,919,985.26	2,915,919,985.26
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,843,672,550.80	5,555,231,536.90
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,962,060,674.12	1,691,323,933.92
2.3.11	Эздийн өмчийн дүн	25,642,376,062.62	28,083,198,308.52
2.4	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	26,290,104,939.57	28,688,166,468.29

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	15,582,340,067.87	16,209,697,796.26
02	Борлуулалтын өртөг	9,020,438,753.79	7,753,391,933.84
03	Нийт ашиг (алдагдал)	6,561,901,314.08	8,456,305,862.42
04	Түрээсийн орлого	1,944,000.00	1,134,000.00
05	Хүүний орлого	5,268,802.84	8,067,087.53
06	Ногдол ашгийн орлого	-	-
07	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
08	Бусад орлого	1,977,225,637.38	1,238,382,668.97
09	Борлуулалт, маркетингийн зардал	3,715,240,396.45	4,457,999,244.19
10	Ерөнхий ба удирдлагын зардал	4,238,598,754.28	4,781,247,915.18
11	Санхүүгийн зардал	72,333,070.55	87,341,780.10
12	Бусад зардал	714,008,737.08	469,872,232.04
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(8,000,000.00)	4,727,272.73
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад зардал	(226,397,031.50)	182,892,460.33
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(428,238,235.56)	(270,736,740.20)
19	Орлогын татварын зардал	526,880.28	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(428,765,115.84)	(270,736,740.20)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(428,765,115.84)	(270,736,740.20)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.26	2,811,702,550.80	2,390,825,789.96	26,039,171,178.46
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.26	2,811,702,550.80	2,390,825,789.96	26,039,171,178.46
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз гарз	-	-	-	31,970,000.00		31,970,000.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(428,765,115.84)	(428,765,115.84)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн	-	-	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.26	2,843,672,550.80	1,962,060,674.12	25,642,376,062.62
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлт	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.26	2,843,672,550.80	1,962,060,674.12	25,642,376,062.62
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз гарз	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(270,736,740.20)	(270,736,740.20)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн	-	-	-	-	-	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	2,711,558,986.10	-	2,711,558,986.10
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,920,722,852.44	-	2,915,919,985.26	5,555,231,536.90	1,691,323,933.92	28,083,198,308.52

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	18,869,809,856.45	18,757,319,224.64
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	17,297,239,208.87	17,385,287,724.39
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Буцаан авсан албан татвар	526,880.28	804,888.47
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	1,572,043,767.30	1,371,226,611.78
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	18,526,680,761.01	18,005,442,318.09
	Ажиллагчдад төлсөн	5,390,013,792.10	7,608,258,905.79
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,845,880,000.00	1,198,125,708.09
	Бараа материал худалдан авахад төлсөн	6,857,556,548.58	4,384,422,638.34
	Ашиглалтын зардалд төлсөн	495,450,266.40	696,446,112.23
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	152,479,715.20	136,501,782.68
	Хүүний төлбөрт төлсөн	72,333,070.55	88,822,021.20
	Татварын байгууллагад төлсөн	1,783,679,483.43	1,943,638,182.99
	Даатгалын төлбөрт төлсөн	10,427,804.00	10,469,758.00
	Бусад мөнгөн зарлага	1,918,860,080.75	1,938,757,208.77
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	343,129,095.44	751,876,906.55
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,268,802.84	8,068,907.81
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
	Хүлээн авсан хүүний орлого	5,268,802.84	8,068,907.81
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
	Бусад	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	616,717,650.00	532,236,140.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	603,847,650.00	522,406,140.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	12,870,000.00	9,830,000.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилга	-	-
	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(611,448,847.16)	(524,167,232.19)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,825,021,178.18	1,559,990,646.43
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,825,021,178.18	1,559,990,646.43

	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,804,021,178.18	1,629,990,646.43
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,804,021,178.18	1,629,990,646.43
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
	Төлсөн ногдол ашиг	-	-
	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	21,000,000.00	(70,000,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(247,319,751.72)	157,709,674.36
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	572,843,066.96	325,523,315.24
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	325,523,315.24	483,232,989.60

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он	2025 он				
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь	
1	Худалдан авсан дулаан	мян.Гкал	678.8	702.6	726.8	24.2	103.4	
	Үүнээс:	Уураар	мян.Гкал	16.7	14.4	15.1	0.7	104.9
		Усаар	мян.Гкал	662.1	688.2	711.7	23.5	103.4
		Худалдаж авсан ДЭХ-ний өртөг	мян.төг	4,968,088.6	2,805,070.0	2,870,883.5	65,813.5	102.3
	ДЭХ-ний алдагдал	хувиар	Хувь	15.26	15.35	15.21	(0.14)	99.1
		биетээр	мян.Гкал	101.0	107.5	108.2	0.7	100.7
	Борлуулах дулааны эрчим хүч	мян.Гкал	577.7	580.7	603.4	22.7	103.9	
2	Нийт орлого	мян.төг	17,566,778.5	16,505,910.0	17,462,008.8	956,098.8	105.8	
	Үүнээс:	Борлуулалтын орлого	мян.төг	15,582,340.1	15,772,110.0	16,209,697.8	437,587.8	102.8
		Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	1,984,438.4	733,800.0	1,252,311.0	518,511.0	170.7
3	Нийт зардал	мян.төг	17,995,016.7	18,222,450.0	17,732,745.6	(489,704.4)	97.3	
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	мян.төг	12,181,326.8	15,240,080.0	14,277,597.6	(962,482.4)	93.7
		Худалдаж авсан ДЭХ-ний өртөг	мян.төг	4,968,088.6	2,805,070.0	2,870,883.5	65,813.5	102.3
		Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	845,601.3	177,300.0	584,264.5	406,964.5	329.5
		ҮХЭ-ийн зардал	мян.төг	1,824,886.6	1,796,700.0	1,909,593.6	112,893.6	106.3
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	(428,238.2)	(1,716,540.0)	(270,736.7)	1,445,803.3	15.8	
5	Татварын дараах ашиг /алдагдал/	мян.төг	(428,765.1)	(1,716,540.0)	(270,736.7)	1,445,803.3	15.8	
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	1.024	1.104	1.016	(0.1)	92.0	
7	Нийт авлага	мян.төг	989,959.3	269,200.0	930,277.2	661,077.2	345.6	
	Үүнээс:	Борлуулалтын авлага	мян.төг	613,033.0	269,200.0	610,762.7	341,562.7	226.9
		Бусад	мян.төг	376,926.2	-	319,514.5	319,514.5	
8	Нийт өглөг	мян.төг	647,728.9	346,100.0	604,968.2	258,868.2	174.8	
	Үүнээс:	УХӨТ	мян.төг	-	30,000.0	-	(30,000.0)	
		БХӨТ	мян.төг	647,728.9	316,100.0	604,968.2	288,868.2	191.4
9	Нийт ажиллагсад	мян.төг	189	193	188	(5.0)	97.4	
10	Нийт цалингийн сан	мян.төг	6,736,391.6	8,434,204.3	8,136,057.3	(298,147.0)	96.5	
11	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт	мян.төг	1,379,928.0	1,826,268.0	1,453,827.2	(372,440.8)	79.6	
	Үүнээс:	Их засвар	мян.төг	815,160.0	1,105,415.0	923,175.20	(182,239.8)	83.5
		ТЗБАХ	мян.төг	273,628.5	210,723.0	101,207.00	(109,516.0)	48.0
		Хөрөнгө оруулалт	мян.төг	291,139.5	510,130.0	429,445.00	(80,685.0)	84.2

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 71,005.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 6,500.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийн арилгах 64,505.3 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүллээ.

3.1 Албан шаардлага

- Тайлант онд байгууллагын 35 жилийн ойн хүрээнд үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зардалд 6,500.0 мянган төгрөг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.4 дэх заалт, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Цалингийн зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын илүү цаг болон нэмэгдэл авч байгаа 10 ажилтны цалинг түүвэрт хамруулж, цалингийн карттай тулган шалгахад 2 ажилтны цалинг 729.7 мянган төгрөгөөр дутуу олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.1-д “Ажил олгогч хуульд өөрөөр заагаагүй бол үндсэн цалинг ажлын байрны шинжилгээ, үнэлгээ, эсхүл ажилтны ур чадварт үндэслэн цагаар, хийснээр, бусад хэлбэрээр тооцно” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ажилтны ажилласан өдөрт ноогдох цалинг үнэн зөв тооцох, хяналт тавьж ажиллах

3.2.2 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

1.2 Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааны үр дүнд тендерт шалгарсан байгууллагад хүргүүлсэн 63,775.6 мянган төгрөгийн гэрээ байгуулах эрх олгох тухай албан бичигт гэрээ байгуулах хугацааг тодорхой заагаагүйгээс тендерийн хороо шийдвэрээс хойш 42-111 өдрийн дараа гэрээг байгуулж ажилласан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох албан бичигт гэрээ байгуулах хугацааг тусгаж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт-ны тоо	Тоо	Дүн
Байгууллагын илүү цаг болон нэмэгдэл авч байгаа ажилтнуудаас 10 ажилтны цалинг түүвэрт хамруулж, цалингийн карттай тулган шалгахад 2 ажилтны цалинг 729.7 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.	1	729.7	-	-	-	-	1	729.7	-	-	-	-
Худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулах албан тоот хүргүүлэхдээ хугацаа заагаагүйгээс тендерийн хороо шийдвэр хүргүүлснээс хойш 42-111 өдрийн дараа гэрээг байгуулж ажилласан байна.	1	63,775.6	-	-	-	-	1	63,775.6	-	-	-	-
Тайлант онд байгууллагын 35 жилийн ойн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зардалд 6,500.0 мянган төгрөг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан байна.	1	6,500.0	-	-	1	6,500.0	-	-	-	-	-	-
Дүн	3	71,005.3	-	-	1	6,500.0	2	64,505.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус байгууллага нь өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 225,750.1 мянган төгрөгийн 26 мэдээллийг хоцроож, 278,355.5 мянган төгрөгийн 7 шийдвэрийг шилэн дансны нэгдсэн системд байршуулаагүй орхигдуулсан байна.	1	504,105.6	-	-	1	504,105.6	-	-
Дүн	1	504,105.6	-	-	1	504,105.6	-	-

